Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology, Vol. 3, № 1(287):60-76 (2007)

СҮХБААТАР АЙМГИЙН НУТАГТ ХИЙСЭН АРХЕОЛОГИЙН СУДАЛГАА (2007)

С.ӨЛЗИЙБАЯР[1]. Д.НАВААН[2], М.ЭРДЭНЭ[2]

[1]ШУА-ийн Түүхийн Хүрээлэн,
e-mail: sulzii70@yahoo.com
[2]МУИС-ийн НШУС-ийн Археологи-Антропологийн Тэнхим,
e-mail: merdene@num.edu.mn

Түлхүүр үгс: *Эртний Монгол, морьтой оршуулга, Онгон, Таван толгой, Өлгий, Өгөөмөр уул, Булган хайрхан, Дулаан уул, булш хиргисүүр сүйтгэгдэж буй тухай*

Өгүүллийн товч агуулга: *Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутаг Ханан бор толгой, Шар хад болон мөн аймгийн Онгон сумын нутаг Тавантолгойд 2007 оны зун явуулсан археологийн судалгаагаар дурсгалын байршлын зургийг үйлдэж, их төлөв дундад үеийн монголын соёлд хамаарах өвөрмөц байгууламж бүхий 8 булш малтан судлав. Тавантолгойд хийсэн монголын үеийн булшны судалгаа нь урьд илэрч байгаагүй оршуулгын зан үйлийн олон элементийг (морь дагалдуулсан, баруун зүг хандуулсан, эмээлийн онцлог чимэглэл, буддын соёлын нөлөө ихтэй) илтгэж байгаа нь монголын үеийн нэгэн соёлыг ялган үзэх боломжтой шинэ эх хэрэглэгдэхүүнийг олгож байгаа юм.*

Хэнтий аймгийн Баянмөнх сумын нутаг Дулаан ууланд геологийн ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа мэдээллийн мөрөөр уг газар хайгуул хийн урьд өмнө судлаачдын харааND өртөөгүй байсан хүрэл, хүннү, түрэг, монголын үеийн археологийн олон дурсгалыг хадгалсан түүх соёлын томоохон дурсгалт газар болохыг илрүүллээ.

2007 оны ҮI сард археологич Д.Наваан, С.Өлзийбаяр, антропологич М.Эрдэнэ нараар удирдуулсан МУИС-ийн археологийн хээрийн шинжилгээний анги Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутаг Ханан бор толгой, Шар хад болон мөн аймгийн Онгон сумын нутаг Тавантолгойд археологийн судалгааг төвлөрүүлэн хийсний дотор дурсгалын байршлын зургийг анх удаа үйлдэж, их төлөв дундад үеийн монголын соёлд хамаарах өвөрмөц байгууламж бүхий 8 булш малтан судлав.

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Ханан бор толгой

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын төвөөс баруун тийш 20 орчим км зайнд байх Ханан бор толгой хэмээх газар археологийн хайгуул, малтлага хийж 13 булш илрүүлэн холбогдох он цагийг урьдчилан тогтоож, бүртгэв. Уулын энгэр газарт 2-3 ширхгээр бүлэглэсэн, бүгд дунджаар 300-350 см голч бүхий цагираг хэлбэрт чулуун далантай, Тавантолгойн бүлэг булшны гадаад хэв шинжийг санагдуулам төстэй зохион байгуулалттай байв. Малтлагыг хийхдээ археологийн дурсгалуудын байршлын зурагт ¹ 1, 2, 7-д бүртгэгдсэн байгууламжуудыг сонгов. Үүнээс эхний

хоёр булш нь зэргэлдээ байрлалтай, гаднах хэв маяг нь ижил учраас хос оршуулгын төрөлд тооцож бид хамтад нь цэвэрлэж, малтах ажлыг эхлүүлсэн билээ.

Хананбор толгой 1-р булш

N 47°05’57,5”
E 111°46’56,9”

420 х 420 см голчтой зөв дугуй цагираг хэлбэрт чулуун далантай, зүүн хойд хэсгээр дараас чулууны өрлөг сэтэрсэн шинжтэй. Цагираг даланг эртний хөрснөөс дээш 2-3 чулуу давхарлан өрж хийсэн учраас төдий л өндөргүй, өргөн нь баруун хэсэгтээ 180 см хүртэл, зүүн талдаа 120 см байгаа нь ерөнхийдөө далангийн баруун этгээдэд чулуу нь илүү овоорсон төлөв ажиглагдаж байна. 80 см гүнээс далангийн төв хэсэгт азимутын 30° хазайсан уртрагийн байрлалтай зуувандуу булшны нүх тодров. Булшны нүх хар саарал өнгөтэй учраас орчны элсэрхэг хөрснөөс тод ялгарч байсан бөгөөд 210 см урт, хойд хэсэгтээ 95 см, урдаа 80 орчим см өргөнтэй болох нь мэдэгдэж байлаа. Нүхээр доош гүнзгийлэн малтахад 110 см гүнээс маш их тоногдож сүйтгэгдсэн байдалтай, нүхний баруун хойд буланд нь хүний ясыг овоолсон авсгүй оршуулга илрэв. Шилбэний ясны байрлалаас барагцаалан үзэхэд хүнээ хойд зүгт хандуулан тавьсан болох нь мэдэгдэхээр байна. Гавлын яс байхгүй, бусад яс нь гүйцэт бус бөгөөд овоорсон ясны зүүн дээд булангаас үсэг товойлгон урласан зэс хөөмөл товруу, түүнийг бэхэлж байсан байж болох товойлгон хээлсэн зэс нимгэн ялтсыг хуйлж, хонгио хэлбэртэй болгосон зүйл, ясны доор төмөр үйлийн хайч тус тус тавьжээ. Монгол оршуулганд үйлийн хайч дагалдуулах ёс маш элбэг болон үүнтэй яг ижил зэс хөөмөл эд ч Буурал уулын булш (Лхагвасүрэн, 1993), Бургалдайн голын хөндий (Батсайхан, Өлзийбаяр, 2006) -н монгол булшнуудад илэрч байсан юм. Түүнээс гадна Сүхбаатар аймгийн Онгон сумын Тавантолгой дахь 5- р булшны (Наваан, 2005) хүрэл толин дээрх ланз хэлбэрт үсгийн дүрс нь бидний өгүүлэн буй зэс хөөмөл олдворын дээрх үсэгтэй адил байна. Энэхүү эртний үсэг, тэмдэгтийн утгыг тайлах нь чухал болох тухай зохиогч өмнө дурдсан (Батсайхан, Өлзийбаяр, 2006) учраас энэ удаа нуршин өгүүлэхээс зайлсхийв.

Хананбор толгой 2-р булш

N 47°05’57,3’’
E 111°46’57,1’’

1-р булшны хойд талд 380 х 310 см харьцаатай өргөргийн шугаман байрлалаар ялимгүй цүлхийсэн байна. Булшны өмнөд хэсгээр далангийн чулуу илүү овоорсон ба хойд хагаст чулуун дараас тун нимгэн байсан нь тонуулчид урд тал руу нь чулууг овоолон хаяснаас үүдэлтэй бололтой. 1-р булшны адил зарчмаар С тэнхлэгийн дагуух дараас чулуунуудыг бүртгэн, зураг дээр тусгайлан тэмдэглэж, булшны нүх мэдэгдтэл зүүн талыг нь доош гүнзгийлэн малтаж, хөндлөн зүсэлтийн зураг эхлүүлэв. Далангийн төв хэсэгт азимутын 58° зүүн хойш хазайсан нүхний толбо тодров. 79 см гүнд нүхний хойд хэсэгт хонины шаант яс тавьсан ба 83 см гүн болоход авсгүй оршуулга бүрэн тодров. Оршуулгын толгойн хэсгээр тонуулчид ихээхэн бусниулсан бололтой бөгөөд их бие, гар хөлийн яс анхны тавилтаараа байсан нь дээш харуулан, тэнэгэр байдалтай умар зүгт хандуулан тавьсан болохыг илтгэж байв. Нас барагчийн толгойг нүүрэн талаар нь хойш нь харуулан, хөмрөн тавьсан нь хожмын тонуулчдын ул мөр бололтой. Толгойн орчмоос дөрвөн дэлбэтэй цэцгэн хээтэй 3 см өндөр, 2 см орчим өргөн ясан бэл (голоор нь нэвт сүвлэн нүхэлсэн хэсгээр бүсний суранд тогтоон, доод үзүүрийн битүү цагирган сэнжинд

хэт зэргийг зүүх зориулалттай)-ний нүүрэн хэсэг, богийн нэг шагай, зориулалт тодорхойгүй төмрийн өөдөс тус тус гарав.

Монгол оршуулганд бүсний шахуурга, түтүүл зэрэг янз бүрээр нэрлэсээр ирсэн нүүдэлчдийн агсарга бүсний үндсэн эд болох бэлийг тогвортой дагалдуулсаар ирсэн байдаг. Түүнийг ихэвчлэн яс, богийн шагайг тууш нүхлэн (Батсайхан, Өлзийбаяр, 2006) хийх тохиолдол элбэг байсан төдийгүй хашаар (Наваан, 2005)-ч нарийн урлан хийсээр ирсэн байна. Ясаар хийсэн монгол булшны бэл нь хэмжээгээр харьцангуй жижиг байдаг нь (1,5 см) дундад зууны монгол эрчүүдийн өдөр дутмын бүс нь шидмэс болон нарийн сураар хийгдсэн байж болох талтайг (Батсайхан, Өлзийбаяр, 2006) өмнө өгүүлсэн билээ. Энэхүү сонирхолтой эдийг нарийвчлан судалснаар монголчуудын агсарга бүсний түүхэн уламжлалыг нэхэн сэргээхэд чухал хэрэглэгдэхүүн болох юм. Хананборын энэхүү 2 булш нь нэгэн цаг үед холбогдох төдийгүй ойр төрлийн хүмүүсийн оршуулга байж болох магадлалтай.

Хананбор толгой 7-р булш

N 47° 05’ 56“
E 111° 46’ 59,7“

1,2- р булшнаас зүүн тийш 200 орчим метрийн зайнд, уулын энгэрт хад, чулуу элбэг газар хөрсөн дээр нэгэн үе өрсөн чулуун овоолготой учраас өнгөц ажиглахад үл мэдэгдэм, ялган танихад хүндрэлтэй. Цэвэрлэн үзэхэд 2 м орчим голчтой, чулуун овоолготой 1,2- р булшнаас ихээхэн өөр зохион байгуулалттай. Дараас чулууны баруун хэсэгт 1 м орчим урттай зуувандуу нүхний толбо тодрон 63 см гүнээс бага насны хүүхдийн оршуулга илрэв. Хөлийн яс ихээхэн хөдөлсөн бөгөөд толгойн байрлалаас үзэхэд хойд зүгт хандуулан тавьсан байна. Ямар нэгэн эд өлгийн зүйл үгүй ажээ.

Шархад 1-р булш

N 46° 54′ 21.7″
E 112° 09′ 39.8″

Мөн сумын нутаг Шархад (сумын төвөөс зүүн тийш 10 орчим км) хэмээх бэсрэг уулсын энгэрт нэгэн булш малтав. Энэ байгууламжийг довцог дээр, чулууг хүрээлүүлэн өрж үйлдсэн байна. Энэхүү дурсгалыг хөрсөн дээрх одоогийн байдлаар нь зураг үйлдэж баримтжуулалт хийсэн ба гар зургаас үзэхэд 6 м голчтой, дугуйрсан маягийн өрлөгтэй булш болох нь анзаарагдаж байна. Төв хэсгийн чулуун дараасыг зайлуулан голд нь цооноглон ухаж эхэлтэл 20 орчим см гүнээс хойд зүгт хандуулан, дээш харуулан тавьсан байрлалтай гавлын яс илрэв. Хэдийгээр маш их сүйтгэгдсэн боловч дагалдуулсан эд өлгийн зүйлээр ихээхэн баялаг бөгөөд ямааны толгой тавьсан нь сонирхол татаж байна. Ясны дундаас 1 ш хутга илэрсэн нь харьцангуй бүтэн 15 см урттай, бариулны модон хэсэг нь үрэгдсэн бөгөөд зэсэн бөгжтэй байсан ажээ. 1ш навчин зэв, ямар нэгэн зүйлийн бүслүүр бололтой зэсэн ороомог, цагариган зуузай, дөрвөлжин төмөр арал зэрэг зүйл тавьсан байв.

Сүхбаатар аймгийн Онгон сум Тавантолгой

2007 оны хээрийн судалгаагаар Сүхбаатар аймгийн Онгон сумын нутаг Тавантолгойд нарийвчилсан хайгуул хийж, Монголчуудын оршуулгын соёлын малталт судалгааг үргэлжлүүлэн явууллаа.

Тавантолгойн Дунд Овоо орчимд хүрэл болон монголын нийлсэн 30 булш илрүүлэн бүртгэсний дотор араваадыг нь өмнө малтжээ. Эндхийн монгол булшнууд цагариг хэлбэрт чулуун далантай, гэрийн буурийг санагдуулам ажээ. Бид анх удаа Тавантолгойн гурван хэсэг газарт хүрэл, монголын нийлсэн нийт 62 булш бүртгэн, археологийн дурсгалын байршлын зураг үйлдэв. Д.Наваанын урьд жилүүдэд малтсан зарим булшны дугаар давхардсан тул байршлын зураг дээр уул дурсгалын дугаарыг өөрчлөн зохих тайлбартайгаар үйлдэв. Тухайлбал, 2004 онд малтсан 6, 2007 онд малтсан 8-р булшнууд ийнхүү давхардсаныг 26, 27-д бүртгэв. Дунд овооны арын хонхорт Хаан, хатны хөшөө хэмээн нутгийн олонд алдаршсан XIII зууныүед холбогдох хүн чулууд байх бөгөөд харамсалтай нь түүний баруун талын булш болон Дунд овооны харалдаа арын дэнжид байрлах хиргисүүрийг (N 45° 06′ 13.6″ E 112° 43′ 01.2″) бидний ирэхээс өмнө хялбар аргаар олз хайгч этгээдүүд тус тус ухаж сүйтгэсэн байна. Өөрөөр хэлбэл, өнгөрсөн жилүүдэд эндээс илэрсэн баялаг олдвор бүхий булшны сургаар ирж ухаж төнхсөн бололтой.

Таван толгой Булш 8 (27).

N 45° 06′ 00″
E 112° 43′ 08.8″

2004 онд археологич Д.Наваанын босгосон чулуун “хөшөө”-нөөс баруун хойш азимутын 295°-т овооны шилэн дээр байрлана. Өргөргийн дагуу 6 м хүртэл сунасан чулуун өрлөг бөгөөд дугуйрсан хүрээтэй мэт харагдах нь урьд жилүүдэд малтсан монгол булштай төслөг мэт байна. Гэтэл цэвэрлэгээ хийж, чулуун өрлөгүүдийг бүгдийг тодруулсны дараа нарийн ажиглахад дунд хэсэгт нь 370 х 280 см харьцаатай дөрвөлжин хашлага мэдэгдэж байв. Хашлагын дотор талбайгаар доош малтахад хавтгай чулуунуудыг маш нарийн зохион байгуулалттай өрсөн нь ажиглагдаж байна. Дөрвөн талын хашлага чулууг хавиргаар нь эртний хөрсөн дээр босгож тавьсан болох нь баруун, зүүн, өмнө талд нь хийсэн малталтаар харагдлаа. Хашлагын гадна, дотно талаас нь хавтгай чулуунуудыг ирмэгээр нь даруулж үелүүлэн өрж, хашлага чулууг бэхэлсэн бөгөөд, дөрвөн талын доторхи налуу өрлөг нь аажмаар доошилсоор төв хэсэгт тэгширч нүхний шалыг үүсгэсэн байна. Шалны гүн 45 см. Нүхний дотор хэсгийг хавтгай чулуугаар битүү бүрхэхдээ дөрвөн ханын чулууг ирмэг даруулан үелүүлсэн, ёроол хэсэгт захыг нь мөргүүлэн өрсөн байна. Хашлагын доторхи чулуун өрөөс ерөнхийдөө бүтэн бөгөөд урд хэсгийн дэрлүүлэн өрсөн өрлөг эвдэрсэн шинжтэй байлаа. Хашлага дотор оршуулга илрээгүй бөгөөд бид чулуун ёроолыг хуулан авч доош малтан үзэхэд эх газрын хөрс тулсан юм. Ингэж дөрвөлжин булшинд чулууг ирмэгээр нь дэрлүүлэн өрснийг зарим судлаачид оньс, цоож хэмээн үзсэн (Наваан, 1975: 48) байдаг нь нэг талаас учир дутагдалтай болох нь бидний энэхүү малтлагаар тодорхой болж байна.

Хашлагын гадуур баруун, зүүн, өмнөд хэсгээр байгууламжийн өргөнтэй адил хэмжээгээр малтан шалгахад ямар нэгэн зүйл эс илрэв. Энэхүү өрлөг нь Дорнод Монгол, Байгалийн наад биеийн зүүн хэсэг, Хөлөнбуйр, Өвөр Монголын хойд хэсгээр төвлөрөн тархсан дөрвөлжин булшны сонгодог хэлбэр бөгөөд оршуулгагүй тахилын байгууламж бололтой. Монгол, Өвөрбайгальд малтсан 542 дөрвөлжин булшийг А.Д.Цыбиктаров судалгаандаа хамруулсны 254 буюу 46,9 % -нь хүний ямар нэгэн ясгүй байсан (Цыбиктаров, 1998: 45) нь оршуулгын зориулалттай бус эсвэл үрэгдэж алга болсонтой холбогдох юм. Судлаач Д.Эрдэнэбаатар хүрлийн үед хийж үлдээсэн дөрвөлжин булшны байгууламж нь оршуулга, тахилын байгууламж гэж хоёр хэлбэртэй болохыг дурдсан байдаг (Эрдэнэбаатар, 2002: 36-37). Тиймээс дөрвөлжин булшны адил оршуулгагүй байгууламж үйлдсээр ирсэн нь элбэг байсныг

бид дээрх судлаачдын бүтээлээс ишлэн өгүүлэхийн учир энэхүү байгууламжийг (8-р булш) оршуулга бус тусгайлан үйлдсэн зан үйлийн нэгэн илрэл буюу хүрэл зэвсэгтний олонтаа үйлдсээр ирсэн тахилын байгууламж гэж тайлбарлахыг зорьсон билээ. Зарим судлаачдын үзэж байгаагаар хүрэл зэвсэгтний үеийн оршин суугчдын үлдээсэн хүнээ дурсан санах мөргөлийн байгууламж гэгч "…гаднах болон доторхи чулуун өрлөгийн зохион байгуулалт нь хүн оршуулсан дөрвөлжин булшны хэлбэрээс онц ялгарахгүй" (Эрдэнэбаатар, 2002: 38) бөгөөд тахилга ёслолын байгууламжийн нэгэн дэд төрөл болгон үзсэн жишээ бий. Энэ мөргөлийн байгууламж гэгчтэй дотор нь ямар нэгэн зүйл хийгээгүйгээр адил мэт боловч дотор талын чулуун өрлөгийн нарийн зохион байгуулалт нь эрс өөр бөгөөд дөрвөлжин булшны чулуун доторлогоотой оршуулгыг санагдуулам байна. Байгууламжийн хүрээлсэн хашлага чулууны ирмэг төдийлөн ялгарч харагдахгүй, дөрвөн булангийн чулуу бусдаас өндөр бус жигд байгаа зэрэг одоогийн хөрсөн дээр мэдэгдэх хэлбэр нь судлаачдын дэвшүүлсэн дөрвөлжин булшны эртний хэлбэр болох Чулуутын шат (МЭӨ XIII-YII зуун) (Цыбиктаров, 1998: 282)-ны дурсгалтай гадна хэв шинжээр туйлын төслөг байна.

Уг дурсгал нь Монгол нутгийн зүүн зах төдийгүй нийт дөрвөлжин булшны тархалтын нутаг дэвсгэрийн зүүн хэсэгт оршиж байгаа нь дөрвөлжин булштаны соёлын үр хөврөл Дорнод Монголд тавигдаж улмаар баруун болон умар зүгт тархсан гэх үзэл баримтлалын үүднээс хандвал энэхүү байгууламж нь эртний хэлбэрийн төлөөлөл байх магадлалыг өндөрсгөж байгаа билээ. Тавантолгойд малтсан дөрвөлжин байгууламж нь эртний хөрсөн дээр өрөгдсөн бөгөөд хашлага дотор ялимгүй хонхойлгон ухаж (хашлага чулууны доод ирмэгээс доош 40-өөд см) хавтгай чулуугаар ёроолд нь шал хийж, улмаар хавиргалан босгосон хашлага чулууны дотор талын бэхэлгээ болох дэрлүүлэн өрсөн чулуунуудын захтай нийлүүлэн битүү зулж доторлосон ажээ. Энд хүн оршуулсангүй, харин сүү, цус зэрэг шингэн зүйл эсвэл махан идээгээр өргөл үйлдсэн нь (нохой, шувууны идэш болсон байж болох) өдгөө бидэнд хадгалагдан үлдээгүй байна.

Таван толгой Булш 9.

N 45° 05′ 59,1″
E 112° 43′ 08,7″

8-р булшнаас урагш азимутын 190°-т 23 метр зайнд байрлана. Хөрсөн дээр уртраг дагуу сунасан дугариг далан хэлбэртэй чулуун өрлөг мэдэгдэж байв. Далангийн голч нь 440 х 410 см харьцаатай өргөрөг дагаж ялимгүй цүлхийсэн цагираг хэлбэрийг үүсгэжээ. Далангийн төв хэсгийг дайруулан уртрагийн зүсэлт хийхийн тулд B, C тэнхлэгийн дагуух чулуунуудыг дугаарлан бүртгэж, дээд талын ирмэгийн хязгаарыг тэмдэглэн авсны дараа тэдгээрийг ховхлон авч оромын гүнийг хэмжих маягаар хөндлөн зүсэлтийн зургийг үйлдэв. 60 см гүнээс далангийн төв хэсэгт өргөрөг чиглэлтэй, азимутын 275°-т хандсан 90 см өргөн, 210 см урттай булшны нүх тодров. Нүхэнд чулуу их хийсэн ба төв болон баруун талаар 100 см орчим гүнд том чулуун чигжээс хийжээ. 188 см гүнээс банзан австай, тоногдож эмх замбараагүй болсон оршуулга илрэв. Авсны баруун буланд ихэнх ясыг овоолсны дотор толгойн ясыг нүүрийг баруун урд булан харуулан, мөрөн дээр байх байдлаар тавьжээ. Хөлийн зарим урт ясны байрлалаас харахад уг оршуулгыг баруун тийш хандуулан тавьсан болох нь илт байлаа. Авсны ёроолыг хусаар хучсан байсан бололтой байна. Хамгийн сонирхолтой нь нимгэн банзан авсны хойд ханыг дагуулан нүхийг ялимгүй хөндийлөн ухаж, баруун тийш харуулсан морины толгой

түүнийг тулган дөрвөн мөчийг давхиж буй байдлаар зэрэгцүүлэн, дээр нь янгиа тавьсан нь нэн сонирхолтой зан үйл ажээ. Урьд өмнө энд малтсан монголын үеийн дурсгалуудаас ямар нэг байдлаар морьтой оршуулсан зан үйлийн шинжүүд илэрч байсан боловч бидний өгүүлэн буй 9-р булшны адил бүтэн морийг төлөөлүүлэн дөрвөн урт мөчийг давхиж буй байдлаар тэнийлгэн, түүний дээр эмээл тавьсан байдалтай оршуулга илрээгүй бололтой. Адууны толгойг шатаасан бөгөөд аманд нь бүдүүн чөмөгтэй цагариган зуузайтай амгай зуулгасан байна. Авсны ёроолд нэг талын бариулын үзүүр хэсэг хугарсныг эс тооцвол бүрэн 21 см урт үйлийн хайч тавьжээ.

Энэхүү 9-р булшны оршуулга ихээхэн тоногдож сүйдсэн хэдий ч нүхний хойд ханыг хөндийлөн ухаж, австай зэрэгцүүлэн тавьсан эмээлийн мод бүхий адууны ясыг хөндөөгүй аж. Эмээлийн модыг морины толгой тал руу харуулан тохсон байрлалтай тавьсан ба уг эдлэл бүрэн хэдий ч олон хэсэг болон салж ихээхэн гажсан учраас эх байдлаар нь эвлүүлэх бололцоогүй болсон байлаа. Гэвч тус эмээлийн булшинд илэрсэн анхны байрлал, эд ангиудын хийц зэргээр нь харьцуулан үзэхэд Хүйтэн хушуу, Ордосын эзэн хороо, Окошка уулын булшны эмээлүүдтэй нэгэн ижил төрлийн болох нь маргаангүй байна. Урд бүүрэг нь 13 см өндөр босоо, нимгэн зэс хяртай, хоёр талын хавтсанд бэхлэх модыг бүүрэгний хоёр үзүүр болгон цавчин хийж түүний ирмэгийг нааш нь товойлгон сийлж нуман хэлбэрт оруулан хооронд нь нийлүүлсэн нь давхар бүүрэгтэй мэт харагдуулах болжээ. Тавантолгойд өмнө жилүүдэд малтсан монголын үеийн булшнаас илэрсэн эмээлүүд нь бүгд ийм хэлбэртэй байв. Хоёр хавтас нь харьцангуй босоодуу байрлалтай учир агтны мундаа дээр нэлээд зай гарсан байхаар хийгдсэн бөгөөд тэр зайнд буюу бүүрэгний доод талын нуман хэлбэрт матаасын доор хүрлээр хийсэн цэцгэн хэлбэрт гогцоо гаргасан нь ямар нэгэн зүйл уяж бэхлэхэд зориулагдсан ажээ. Өмнөговь аймгийн Хар аргалантын монгол булшнаас урд бүүрэгний нүүрэн талд нь нэжгээд төмөр цагирган гогцоо хадсан тухай Волков тэмдэглэсэн байна (Лхагвасүрэн, 2007: 221). Хүйтэн хушууны эмээлийн урд бүүрэг нь босоо, уужим суудалтай, хойд бүүрэг нь өргөн налуу бөгөөд мөн л урд бүүргийн нүүрэн талд хоёр төмөр гогцоо бэхэлсэн байна. Тавантолгойн 9-р булшны эмээлийн хийц нь урьд өмнө олдоод байгаа монголын үеийн эмээлүүдтэй ерөнхийдөө хийц маягаар ижил боловч урд бүүргийн доод талд мөнөөх гогцоог бэхэлснээрээ ихэд ялгаатай аж. Магадгүй энэ гогцоог бэхлэх зорилгоор зориуд урд бүүргийн дор давхар хөмсөг гаргасан бололтой. Бидний бодлоор уул гогцоогоор адуучин суран бугуйлын үзүүрийг сүвлэн оруулж байсан мэт. Учир нь бугуйлдсан агтыг арагш налж татахад хүчийг сааруулах зорилгоор хийгдсэн бололтой бөгөөд хойд бүүрэг нь далбагар налуу учир адуучин эр ард нь сууж татах боломжгүй юм. Энэ шийдэл нь Хүйтэн хушуу болон бусад газрын эмээлийн боловсронгуй загвар бололтой. Эмээлийн хойд бүүрэг нь маш өргөн, гэдгэр, далбагар хийгдсэн нь суудлын зориулалттай ажээ. Суудлыг бэхлэхдээ хавтсанд углуургадан, ирмэгүүдийг нарийн сураар үдсэн байна. Суудлын (хойд бүүрэг) ар талд нь мөн л нуман хэлбэрт матаас хийсэн нь ихээхэн сонирхолтой байна. Тухайлбал ямар зориулалтаар ингэж хөмсөг гаргасан нь тодорхойгүй (урд бүүрэгний хөмсгийг гогцоо бэхлэх зориулалттай гэж үзвэл), гоёл хэмээн үзэхэд хүний нүдэнд ил харагдахгүй далд ажээ. Хоёр хавтсанд углуурга гаргаж бүүргийг тогтоон нарийн сураар үдсэн байна. Хавтасны нийт урт 40,8 см, хойд талдаа ганзаганы 4, нийт 8 нүхтэй бөгөөд эдгээр нүх тус бүрт цэцгэн тавтай мөн тийм хэмжээний хүрэл гогцоо бэхэлсэн болон хойд үзүүр хэсэгт нь навч хэлбэрийг дүрсэлсэн тоонолжин хээтэй даруулга бэхлэн, түүний хоёр үзүүрт сурны тасархайтай сэнж гаргасан байна. Хоёр этгээдийн хавтас урд талын бүүрэгнээс

урагшаа 5 см орчим илүү гарсны дээр мөн адил ганзаганы хүрэл гогцоо хошоодыг бэхэлсэн ба мөн эдгээрийн доод талд нь чухам юунд зориулагдсан нь үл мэдэгдэх тус бүр нэг нүх байна. Харин суудлын хэсэгт (хоёр бүүрэг хооронд) дөрөөний сурын 2 см орчим өргөн хавтгай нүх гаргасан ба түүний доод талд хоёр эгнээ үдээсний нүх байна. Эмээлийн хавтсанд бэхэлсэн 12 (хойд талд нь 8) гогцоо нь ганзагны зориулалттай хийгдсэн ба мөн нөгөө талаар чимэг (баавар) болж байж. Ийнхүү 9- р булшны зан үйл нь монголчуудын оршуулгын мэдэгдээд байсан урьд өмнөх уламжлалын тухай бидний мэдлэгийг ихэд баяжуулсан эрдэм шинжилгээний ихээхэн ач холбогдолтой эх хэрэглэгдэхүүн болж байна.

Таван толгой Булш 10.

N 45° 05′ 58,9″
E 112° 43′ 08″

9-р булшнаас баруун хойш азимутын 280° ын байрлалд 17 метр зайнд оршино. Хөрсөн дээр дугариг чулуун дараас үүсгэхдээ далангийн хойд тал тасарсан байдалтай ба зүүн хэсгээр бусдаас илүү зузаан далантай мэт харагдаж байлаа. Далангийн хэмжээ 530 х 490 см харьцаатай, төв хэсэгтээ 250 см голчтой зөв дугуй хэлбэр үүсгэсэн байна. Малтлага 130 см гүн болоход нүхний төв хэсэгт хавиргаар нь босгосон хавтгай чулуу илрэн 135 см гүнд хойш нь харуулан тавьсан адууны толгойн хамт мөн чулуунаас урагш зэллэн босгосон чулуун хаалт тодров. Морины толгойн яс хэдийгээр маш муудсан ч хоёр талдаа S хэлбэрийн сэртэнгитэй маш өвөрмөц цагирган зуузайтай, бүдүүн чөмөгтэй амгай зуулгасан байна. Хошуувч мэт төмөр нарийн эдийг хамрын үзүүр хэсэгт бөгжилсөн байдалтай тавьж түүнтэй зэрэгцүүлэн хамрын ясыг дагуулан хазаарын чимэг байж болох хөндлөн нарийн төмөр 5 ширхэгийг тавьжээ. Эндээс үйсэн хоромсого, бүүрэгний алтаар шарсан төмөр ялтасны хэд хэдэн өөдөс олдсон юм. Энэхүү шармал хуудас нь эмээлийн бүүргийг битүү бүрхэн байсан бололтой бөгөөд луу болон цэцгийг нарийн ур гарган товойлгон хээлсэн байна. Өмнөх жилүүдэд Д.Наваанын малтан шинжилсэн булшнаас хээтэй мөн чимэг олдож байсан нь энэхүү бүлэг булшны соёлын нийтлэг шинж бололтой. 145 см гүнд авсны таган дээр мөрөн дээрх байрлалаар тавьсан гавлын яс гарч 150 см гүнээс 230 см урт 95 см өргөн, дээгүүр нь улаан, цагаан өнгөөр хослуулан будаж гоёмсог байдлаар хээлсэн, 30 см өндөр банзан австай байсан бололтой оршуулга илрэв. Авсыг 30 см бүрт 2 см өргөн металл туузаар бүслүүрдсэн ором байна. Монголын Юан улсын хаадыг оршуулах зан үйлийн тухай хятад сурвалжид "…түүний дотор (авс) шарилыг хийж гадуур нь будаг, шир тавьж дахин шижир алтан цагиргаар гурав цагираглаж, умар зүг онгоны газарт ирж булж оршуулдаг" (Баясах, 1989) гэж өгүүлсэн байдаг ажээ. Эдгээр мэдээтэй дүйлгэн үзвэл уг оршуулга нь эгэл угт хүмүүний булш яавч биш ажээ. Дунд хэсгээр нь нарийн сураар ороосны ул мөр үлдэж хоцорсон 1,5 см өргөнтэй, 13 см урт нарийн хутганы модон иш, хүрэл хонх (хэлгүй) маягийн эдлэл, алтан утсаар бэхэлсэн хаш, номин зэрэг чулуугаар уралсан ээмэг бололтой зүйл, хос нүхтэй хаш чулуун эд (бариул хэсэг байж болох), чулуун бөөрөнхий зэрэг зүйл толгой орчмоос олдсон бөгөөд хойд ханыг хөндийлөн ухаж зэс аяганы хагархай дээр үхрийн нуруу, шилбэний яс, хонины шагайт чөмгийг тус тус тавьсан байна.

Хүний оршуулгыг хавиргалан босгосон чулуун хаалтын баруун хэсэгт тавьсан бөгөөд зүүн талын том зайнд адууны толгой илэрсэн байдлаас дүгнэхэд морьтой нь оршуулсан бололтой юм. Гэвч толгойноос өөр яс олдоогүй нь чухам ямархуу байдлаар адууг тавьсан нь тодорхойгүй ч том нүхэнд чулуун хашлагаар

хүнээс заагалсан байдлаас үзэхэд анх бүтэн морь тавьсан байж болох юм. Тонуулчид уул оршуулгыг дөнгөж хийсний дараахан бусниулахдаа уг адууны толгойг үлдээн бусад хэсгийг авч одсон байж болох мэт. Монголчуудын ядуу хэсгийнхний амьдрал маш дорой байсан тухай жуулчдын тэмдэглэлд дурьдсан буй (Плано Карпини,1988). Хүний ясны байрлалаас харахад уг оршуулгыг хойд зүгт хандуулан тавьсан бололтой. Нийт гүн 190 см болов.

Таван толгой Булш 11.

N 45° 04′ 40.5″
E 112° 43′ 04.0″

Дунд овооноос урагш 3 км орчим зайтай орших жижиг толгойн өвөрт байрлана. Чулуун дараас нь тодорхой хэлбэр үүсгэгүй, сонгодог монгол булшны төлөөлөл бөгөөд дугуйрсан чулуун далантай, далангийн төв хэсэгт чулуун овоолготой, хойд талд нь хөшөө мэт гозгор чулуутай байгууламж байв. Дараас чулууны төв хэсэгт 180 х 150 см харьцаатай өргөргийн байрлалтай малтан 160 см орчим гүнд оршуулганд хүрэхэд угсаатан судлалын асар өндөр ач холбогдол бүхий хэрэглэгдэхүүнийг хадгалсан, тоногдоогүй булш гарсан. Хүнийхээ толгойг баруун тийш чиглүүлэн тавьсан бөгөөд хойд талд нь сум дүрсэн, геометрийн дүрсэн хээтэй, ясан ялтсан чимэглэл бүхий үйсэн хоромсого тавьсан байв. Хоромсого дотроос 5 янзын зэв мөсний хамт олдсон байна. Хоромсогын дээр адууны толгой тавьсан нь маш муу хадгалагджээ. Хоромсогын дэргэд босоогоор илд байсан бололтой нарийн урт төмөр эдлэлийг тавьсан нь хэд хэдэн хэсэг болсон байсан ба хамгийн урт нь 20-д см урттай байлаа. Хүний толгойн дэргэд жижигэвтэр мөнгөн аяга тавьсан байсан нь маш их муудаж эвдэрсэн байв. 50 см урттай эмээлийн хавтас, өрөөсөн төмөр дөрөө, морины аманд зуулгасан байсан бололтой цагирган зуузай оршуулгаас олдсон нь мөн л морьтой оршуулга байсныг илтгэж буй хэрэг юм.

Хорь орчим насны залуу эрэгтэй хүнийг таггүй банзан авсанд оршуулсан ба шар торгон дээл, малгайтай байсан нь хувцасны үлдцээс тодорхой байна. Хувцасны үлдэц маш муу хадгалагдсан ч лабораторийн нөхцөлд цэвэрлэн сэргээж харьцангуй бүтэн хадгалагдсан хэсгүүдээс нь тоймлон үзэхэд боровтор өнгийн торгомсог эдээр хийж ногоон эдээр доторлосон ханцуйтай, ханцуйгүй 2 янзын дээл илэрч байгаа ба нэг нь нимгэн хөвөн зулж доторлосон, нөгөө нь даавуу дотортой тэрлэг бөгөөд дээлийн хормой ардаа эсвэл хоёр хажуудаа 40 см хүртэл оноотой болох нь харагдаж байна. Ийм оноотой дээл монгол булшнаас олдож байсныг Д.Баяр дурьдсан байдаг (Баяр, 2000). Нас барагчийн авсны толгой талаас малгай олдсон нь харьцангуй сайн хадгалагдсан байв. Уг малгай нь юүдэн хэлбэртэй, бор өнгийн хээтэй торгомсог эдээр хийж доторлосон, эрүүвч, шилэвч нь тусгай эсгүүр зүйдэлтэй бөгөөд шанаандаа бүчтэй, эрүүвчиндээ гогцоотой ажээ. Малгайн оройд ижил эдээр цэцгэн хэлбэртэй сампин хийж тогтоосон, ар шилэнд жижиг сампин зангидаж бэхэлсэн нь эрүүвчний гогцоогоор товчилдог бололтой. Уг булшнаас олдсон ихээхэн сонирхолтой олдворын нэг бол бүс юм. Уг бүс нь болроор хийсэн бэл, гархи, бүсэнд хадаж бэхлэх зориулалттай болор товруу, зэс арал зэргээс бүрдэх бөгөөд бэлийн гогцоонд ямар нэг зүйлийг бэхэлж байсан бололтой сурны өөдөс хамт олджээ. Эгийн голын монгол оршуулгаас ясаар хийсэн боловч яг адил бүсний эдлэл олдож байжээ (Лхагвасүрэн, 2007:92). Энэхүү булшнаас гарсан ховор нандин олдворуудаас харахад уг булш нь дундад үеийн монголын эгэл бус язгууртан хүний оршуулга болох нь тодорхой байна.

Д.Наваан урьд жилүүдэд Сүхбаатар аймгийн нутгаар ажиллахдаа Тавантолгойн бүлэг булштай гадна байдлаар төслөг дурсгалын тархалт нь зөвхөн Онгон сумын нутгаар хязгаарлагдахгүй, Мөнххаан сумын Хананбор, Шартын хад, Замын хошуу зэрэг газруудад тохиолдож байгааг урьдчилан тогтоосныг бид энэ удаагийн хээрийн шинжилгээний хүрээнд малтан шалгав. Хэдийгээр Хананбор, Шартын хад зэрэг газарт малтсан булш нь гадна хэв шинжээр Тавантолгойн бүлэг булштай төслөг хэдий ч оршуулгын зан үйлээр ихээхэн өөр болох нь ажиглагдлаа. Эдгээр булшнаас Тавантолгойн адил морьтой оршуулгын зан үйл огт илрээгүй боловч, монгол булшны тогтвортой нийтлэг зан үйл болох шагайт чөмөг, цагирган зуузай дагалдуулах зэргээрээ ижил байлаа.

Тавантолгойн бүлэг булшийг судалсан 3 жилийн судалгааны үр дүнг нэгтгэсэн бүтээл туурвих нь чухал бөгөөд энэ жилийн судалгаагаар өмнөх жилүүдийн адил монголын үед холбогдох морьтой оршуулгууд илрэв. Өмнөх жилүүдэд энд хийсэн судалгаагаар зарим булшинд (2, 5-р булш) бүтэн морийг тавьсан тухай өгүүлсэн байдаг бол энэ жилийн 9-р булшны малтлагаар морины дөрвөн мөч, толгойг төлөөлүүлэн тавьсан, 10-р булшинд бүтэн морь дагалдуулсныг магадгүй тонуулчид авсан байж болох, 11-р булшинд адууны толгойг хоромсогын дээр тавьсан байна. Тавантолгойн бүлэг булшинд адууг чулуугаар зааглан (5, 10-р булш) бүтнээр нь тавих, зөвхөн толгой дөрвөн шийрийг тавих (9-р булш) зэрэг хэлбэрээр дагалдуулж байжээ. Эндээс тогтвортой олдож байгаа эд өлгийн зүйл бол эмээл бөгөөд тэр нь эдүгээ монголчуудын дунд нэгэнт мартагдсан (байсан эсэх) бүүргийг луу, цэцгэн хээ тавьж, битүү алтадсан металл ялтсаар бүрсэн болон ердийн модон янгиа гэсэн хоёр янз байжээ. Д.Наваанын өмнөх судалгаагаар дээл илэрч байсан бөгөөд энэ жил 11- р булшнаас мөн дээл бололтой (дээлээс гадна малгай, цамц маягийн хувцас) хувцас олдсон байна. Эдгээр дээл нь ташаандаа гүнзгий ухлаадастай байгаа нь Окошка уулын монгол язгуартны дээлтэй төслөг байна. Ийнхүү Тавантолгойд хийсэн монголын үеийн булшны судалгаа нь урьд илэрч байгаагүй оршуулгын зан үйлийн олон элементийг (морь дагалдуулсан, баруун зүг хандуулсан, эмээлийн онцлог чимэглэл, буддын соёлын нөлөө ихтэй) илтгэж байгаа нь монголын үеийн нэгэн соёлыг ялган үзэх боломжтой шинэ эх хэрэглэгдэхүүнийг бидэнд олгож байгаа юм. 1984 онд Читийн БДС-ийн Дээд Амарын археологийн дурсгалыг судлах экспедици Бооржийн амны Өлгий хэмээх газар монголын үед холбогдуулан үзсэн хоёр булш малтжээ. Хүнээ баруун хойд зүгт хандуулан өвөрмөц модон авсанд оршуулахдаа авсны зүүн талд нь морийг төлөөлүүлэн түүний толгой, дөрвөн мөчийг дэлэн тавьж, дээр нь модон янгиа тавьсан нь (Ковычев, Беломестнов, 1985) Таван толгойн 9- р булшны зан үйлтэй туйлын төслөг төдийгүй эмээл, цагирган зуузайн хэлбэр зэргээрээ адил байна. Бид энэ талаар цаашид гүнгийрүүлэн судлаж байгаа учраас олон зүйлийг эс нуршив.

Буриадын эрдэмтдийн 20-иод жилийн өмнө нээсэн Умард Монгол, Баруун Өвөрбайгальд ҮII зууны орчим үүсч хойцегорийн (ҮII-Х), саянтуйн (Х-ХIҮ) гэх хоёр шатыг дамжин хөгжсөн “Эртний Монголын” археологийн соёлын онолын үзэл баримтлалыг Ц.Төрбат нарын манай зарим судлаачид (Төрбат, Батсайхан, 1997; Төрбат, Амартүвшин, Эрдэнэбат, 2003: 114-119) ихээхэн дэмжиж байгааг эс дурдвал бид дэлхийн гүрнийг байгуулж явсан их өвгөдийнхөө үеийн археологийн соёлыг нилээд хангалтгүй мэдэж байгаагаас уг соёлын нийтлэгийн үүсэл, хэлбэршил, ондоошил, орон нутгийн өвөрмөц хэв маяг төдийгүй тархацын асуудлаар ч нэгдмэл бүү хэл ноёлох үзэл баримтлалтай болж чадахгүй байна.

2001 онд Д.Наваан Архангай аймгийн Өндөр-Улаан сумын нутаг Булган хайрхан уулын энгэрт олон булш малтсаны нэгээс нь "…адууны бүхэл араг яс гарч толгой, гэдэс, ууц, нуруунд төмөр олом зэргийг тавьжээ. Баруун хавирга (гэдсэн) дээр хонины хонт шагай тавьсан" (Наваан, 2001) оршуулга илэрчээ. Уг байгууламжийг зохиогч монголын үед хамаатуулан үзжээ. Гэтэл 2006 онд Сэлэнгэ аймгийн Сант сумын Өгөөмөр уулнаа С.Өлзийбаяр уйгурын үед холбогдуулан үзсэн "…морины гэдсэн дээр хонины шаант чөмөг тавьсан" (Өлзийбаяр, 2007) нэгэн өвөрмөц оршуулга илрүүлсэн нь уул хоёр ихээхэн төслөг байна. Эдгээр булшнуудын дурдсан зан үйл нь судлаачдын анхаарлыг татсаар ирсэн хойцегорийн соёлын мөн чанарыг тодруулахад чухал ач холбогдолтой бөгөөд "эртний монголчуудын" оршуулгын соёлын үнэтэй хэрэглэгдэхүүн болж болох юм. Шагайт чөмгийг дагалдуулах ёс нь сонгодог монгол булшны тогтвортой зан үйл төдийгүй энэ соёлын бусдаас ялгарах шинж хэмээх үзлийг дэмжвэл эртний монголын соёлд, харин ваар дагалдуулсан морьтой оршуулга нь түрэг угсааны нүүдэлчдийн гол шинж хэмээн үзвэл дээрх булшнууд нь зохиогчийн дэвшүүлсэн уйгур булшны төрөлд орох ажээ. Гэтэл шагайт чөмөг, морь дагуулсан дээрх хоёр булш нь ихээхэн холимог шинжтэй бөгөөд түрэгийн соёлын нийтлэгийн хүрээнд шагайт чөмөг үзэгдэж эхэлсэн эсвэл эртний монголын оршуулгын соёл мөн адил нүүдэлчдийн цаг хугацаа, орон зайн өргөн хүрээнд тархсан морьтой оршуулгын хэлбэртэй үүсээд хөгжлийн явцад морь дагалдуулах уламжлалыг орхиж сонгодог монгол булшны хэлбэрийг олсон байж болох хоёр хувилбарын уулзвар дээр байгаа дурсгал юм. Ямартай ч морины гэдсэн дээр шагайт чөмөг тавьсан түрэг, монгол зан үйлийн илрэл холилдсон завсрын шинжтэй энэхүү оршуулганд (Өгөөмөр уулын) YII-YIII зууны үед өргөн тархсан S хэлбэрт зуузай, босоо сэнжит дөрөөнөөс гадна Харбалгас зэрэг газраас олддог "уйгур" хээтэй ваар дагалдуулсан зэрэг нь Уйгур улсын үеэс ийм зан үйл бүхий оршуулга хийгдэх болсныг харуулж байгаа юм. Эдгээр морьт оршуулгын шагайт чөмөг нь сонгодог монгол булшинд уламжлагдсан болон хожуу Тавантолгойн бүлэг булшинд морь дагалдуулах ёс дахин давтагдсан нь Коновалов нарын "эртний монголын" (Коновалов 1989:5-20) хэв шинжит Хойцегорийн шатны нэгэн хэлбэрийн дурсгал байж болох санал дэвшүүлэх боломж бидэнд олгож байна. Тиймээс бид Өгөөмөр уулын Уйгурын үед холбогдуулан үзсэн морьтой оршуулга, Д.Навааны сонгодог монгол булшны адил үзсэн Булган хайрханы морьт оршуулгыг "эртний монгол"-ын археологийн соёлд хамаатуулан тайлбарлаж байна. Ингэснээр эртний монголын угсаа-соёлын үйл явцын төв Өвөр Байгалийн баруун хэсэг, магадгүй Умард Монгол, Орхон-Сэлэнгийн сав нутагт МЭ I мянган жилийн II хагасын эхэн үед бүрэлдэн тогтсон (Төрбат, Батсайхан 1997, Төрбат, Амартүвшин, Эрдэнэбат 2003:114-119) хэмээх үзэл баримтлалд ихээхэн дэм болж болох чухал эх хэрэглэгдэхүүн гэж үзэж байна.

2004 онд Д.Наваан Их Монгол улсын нийслэл байсан Хархүрэм хот, мөн Монголын Юань гүрний нийслэл байсан Дайду хотуудын дунд оршиж байгаа (Наваан, 2005) байдлаар Юань улсын үед холбогдуулан үзсэн Тавантолгойн соёл нь дундад эртний Монголын үеийн оршуулгын зан үйлийг улируулан судлахад тулгуур судалгаа болох юм. Иймээс Тавантолгойд малтсан булшны хэрэглэгдэхүүнийг лабораторийн нөхцөлд дахин нарийвчлан судлах, Дунд Овооны арын хонхорт буй дундад үеийн монголын хаан, хатны хөшөөтэй нягт уялдаатай авч үзэх нь арга зүйн нэгэн шинэ хандлага болох юм. Ингэснээр Монголын үеийн ноёлог давхаргын хүмүүсийн оршуулгыг судлахад ихээхэн практик ач холбогдолтой судалгаа болох билээ.

Хэнтий аймгийн Баянмөнх сум

Хэнтий аймгийн Баянмөнх сумын нутаг Дулаан ууланд хятадууд газар ухаж жонш олборлож эхлээд буй мэдээг нутгийн иргэн П.Манцуйт, З.Ням-Осор нар 2007 оны эхээр зохиогчид (С.Ө) дуулгасан билээ. Бид мэдээллийн мөрөөр Сүхбаатараас буцах зам зууртаа Дулаан уулнаа ажиллан урьд өмнө судлаачдын харанд өртөөгүй байсан хүрэл, хүннү, түрэг, монголын үеийн археологийн олон дурсгалыг хадгалсан түүх соёлын томоохон дурсгалт газар болохыг илрүүллээ. “Их Мянганы үүд” гэгч уул уурхай эрхлэх тусгай зөвшөөрөлтэй компани ашиглалтын зорилгоор газар ухаж эхэлсэн байсан бөгөөд түүнээс 20 хүрэхгүй метрийн зайнд хиргисүүр, дөрвөлжин булш (46° 44' 53,1" 109° 56' 55,9" болон 46° 44' 54,2" 109° 56' 50,7") байгаа нь тогтоогдсон болно. Олон хэсэг газруудад том талбайгаар хөрс хуулалт хийхэд булш, хиргисүүр өртсөн байж болох бүрэн магадлалтай байна. Энэ үйлдэл нь Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийг ноцтой зөрчсөн боловч Ашигт малтмалын тухай хуулийн дагуу ашиглалтын лицензийг АМГТХЭ газраас авсан нь манай хуулийн заалтуудыг хооронд нь уялдуулах шаардлагатай болохыг амьдралаар шалгасан хэрэг болсон юм. Дулаан ууланд археологийн нарийвчилсан судалгаа хийх, авран хамгаалах, малтах эрх Соёлын өвийн тухай хуулийн дагуу МУИС-ийн Археологийн тэнхимд хадгалагдах юм.

ТАЛАРХАЛ

Энэхүү судалгааг МУИС-ийн Азийн Судалгааны Төвийн санхүүжилтээр гүйцэтгэдэг “Дорнод Монгол” төслийн хүрээнд гүйцэтгэлээ.

НОМ ЗҮЙ

Батсайхан З., Өлзийбаяр С., 2006. 2005 онд Сэлэнгэ аймгийн нутагт археологийн судалгаа хийсэн тухай. Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology, Vol. 2, ¹ 2 (271): 57-66

Баяр Д., 1999. Алтан ургийн язгууртны нэгэн булшийг судалсан нь УБ.

Баясах Ж., 1989. Чингис хааныг оршуулсан тухай хятад сурвалжийн мэдээ. ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн архив

Ковычев Е.В., Беломестнов Г.И., 1985. Погребения с конем из Поононья: Хронология и этническая принадлежность.

Коновалов П.К., 1989. Корреляция средневековых археологических культур Прибайкалья и Забайкалья. Этнокультурные процессы в Юго-Восточной Сибири в средние века. Новосибирск

Лхагвасүрэн Х., 1993. Буурал уулын монгол булшнууд. Түүхийн судлал, Т. XXIII, fasc. 15

Лхагвасүрэн Х., 2007. Монголын археологи (Чингис хааны үе) I дэвтэр, УБ.

Наваан Д., 1975. Дорнод Монголын хүрлийн үе. УБ.

Наваан Д., 2001. Хануйн хөндийн монгол булшнууд. Чингис хаан судлал, t.III, f.XI. УБ.

Наваан Д., 2005. 2004 онд хийсэн археологийн ажлын тайлан, МУИС-ийн Антропологи-Археологийн тэнхим

Өлзийбаяр С., 2007. Өгөөмөрийн уйгур булш. Түүхийн судлал, Т. XXXYII, fasc. 3. УБ.

*Плано Карпини,*1988. Монголчуудын түүх. УБ

Төрбат Ц., Батсайхан З., 1997. Эртний монголчуудын археологийн дурсгалыг судлах асуудалд (МЭ YIII-XY зуун). МУИС-ийн ЭШБ. Т. 9 (126), f. XYII. УБ.

Төрбат Ц., Амартүвшин Ч., Эрдэнэбат У., 2003. Эгийн голын сав нутаг дахь археологийн дурсгалууд. УБ.

Цыбиктаров А.Д., 1998. Культура плиточных могил Монголии и Забайкалья. Улан-удэ

Эрдэнэбаатар Д., 2002. Монгол нутгийн дөрвөлжин булш, хиргисүүрийн соёл. УБ.,

SUMMARY

S.Ulziibayar, D.Navaan, M.Erdene

ARCHAEOLOGICAL SURVEY AND EXCAVATION IN SUKHBAATAR AIMAG, EASTERN MONGOLIA (2007)

Archaeological investigation was conducted at the Khanan bor and Sharkhad sites, Munkkhaan soum, and Tavantolgoi site in Ongon soum, Sukhbaatar aimag, Eastern Mongolia. During the expedition we mapped archaeological monuments at the Khanan bor and Tavan tolgoi sites and excavated eight graves, mostly belonging to medieval Mongolian period. Excavation of the graves at Tavan tolgoi site revealed many interesting elements (such as horse association, west orientation of the burials, specific decoration of saddle, much influence of the buddhist religion) of the burial culture of Mongolians which lead us to suppose about one of the distinct cultures of medieval Mongolians.

Archaeological survey at Dulaan uul mountain site revealed several monuments from Bronze, Xiongnu, Turkic and Mongolian periods unknown to scientists before.

Зураг 1. Ханан бор 1, 2-р булш (зүүн талаас)

Зураг 2. Ханан бор 1- р булшны оршуулга (зүүн талаас)

Зураг 3. Ханан бор 7-р булш (зүүн талаас)



Зураг 4. Таван толгойн археологийн байршлын зураг



Зураг 5. Тавантолгой 8-р булш

Зураг 6. Тавантолгой 9-р булш (урдаас)

Зураг 7. Таван толгой 9-р булшны оршуулга (урдаас)

Зураг 8. Тавантолгой 9-р булш. Янгиа

Зураг 9. Тавантолгой 10-р булш (урдаас)

Зураг 10. Тавантолгой 10-р булш. Эмээлийн ялтсан чимэг

Зураг 11. Тавантолгой 10-р булш. Адууны толгой

Зураг 12. Тавантолгой 11-р булш

Зураг 13. Тавантолгой 11-р булш. Хоромсого, адууны толгой

Зураг 14. Тавантолгой 11-р булш. Хоромсого

Зураг 15. Тавантолгой 11-р булш. Дээлийн хормой хэсэг, малгай

Зураг 17. Тавантолгой 11-р булш. Бүсний болор чимэг